БАТЛАВ
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
А.ЭНХМАНЛАЙ

“ГАЗАР ЗҮЙН АТЛАС”-ЫГ АНГЛИ ХЭЛ ДЭЭР ШИНЭЧЛЭН ЗОХИОХ, ХЭВЛҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 01 сарын 19 өдөр Дугаар А2/2024-03 Улаанбаатар хот

Д/д	Ажлын нэр, төрөл	Тайлбар
1.	Ажлын үндэслэл	- Геодези, зураг зүйн тухай хууль; - ГЗБГЗЗЕГ-ын 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө.
2.	Ажлын зорилго	2013 онд англи хэл дээр зохиож, хэвлэгдсэн Газар зүйн атласыг 2023 оны мэдээллээр баяжуулж шинэчлэн англи хэл дээр зохиох, хэвлүүлэх.
3.	Хамрах хүрээ	Газар зүйн атлас дахь 21 газрын зураг.
4.	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсан өдрөөс 5 сар.
5.	Ажлын иж бүрдэл	Газар зүйн атласын 21 газрын зургийг шинэчлэн зохиох, хэвлэлийн эх бэлтгэх ажлын хүрээнд дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд: 1. Газрын зургуудын мэдээллийг шинэчлэх: - Редакци, зохиолтын эх бэлтгэх ажил; - ГЗБГЗЗЕГ болон холбогдох байгууллагуудаас авто зам, төмөр зам, ашигт малтмалын орд газар зэрэг мэдээллийг авна. (Жишээ нь: Үндэсний статистикийн хороо, Ашигт малтмал, газрын тосны газар болон бусад холбогдох байгууллага). 2. Англи хэл дээр зохиох: - Өмнөх үг болон сэдэвчилсэн газрын зургуудын нэр болон таних тэмдгийг англи хэл рүү орчуулах; - Газрын зургуудад туссан аймаг, нийслэл, сум дүүргийн нэр болон бусад газар зүйн нэрийг галиглах. 3. Хяналт хийх: - Зохиолтын эхэд хяналт хийлгэх; - Редакцийн хяналт хийлгэх; 4. Хэвлүүлэх ажил: - Хэвлэлийн эхийн хяналтыг өнгөт сорьц хэвлэн гаргаж хийлгэх; - Редакцийн хяналтын дагуу засварыг хийх; - Гүйцэтгэсэн ажлын тайлан бичиж, ажлын үр дүнг АМХ-т хүлээлгэн өгөх; - Хэвлэлийн эхийг хянах.
6.	Техникийн шаардлага	Барилга, хот байгуулалтын Сайдын 2022 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 174 дугаар тушаалаар батлагдсан “Газрын зураг, атласын редакц, зохиолт, хэвлэлийн эх бэлтгэх, хяналт хийх дүрэм”-ийг баримтална.

		Газар зүйн атласын газрын зургуудад хамаарч буй газар зүйн нэрийг галиглахдаа Монгол кирилл үсгийн латин хөрвүүлэг MNS 5217:2012 стандартыг баримтална. Газар зүйн атласын газрын зургуудыг 2023 оны мэдээллээр өөрчлөлт оруулж, шинэчилсэн байна. Үүнд: 1. Өмнөх үг хэсгийг шинэчилнэ. /ГЗБГЗЗЕГ-аас бэлтгэх, санал авах/; 2. Хуудас 6-7. Зураг 1. Geographic location of Mongolia газрын зурагт дэлхийн улсуудын нэрийг нийслэлийн байршлын хамт тэмдэглэх (ГХЯ-аас улсуудын нэрэнд санал авах); 3. Хуудас 8-9. Зураг 2. Map of physical geography газрын зургийн замын мэдээллийг шинэчлэх (Зам, тээвэр хөгжлийн яамнаас санал авах); 4. Хуудас 10-11. Зураг 3. Administrative division; 5. Хуудас 12-13. Зураг 4, 5. Population (Үндэсний статистикийн хорооноос мэдээлэл авах, санал авах); 6. Хуудас 14-15. Зураг 6. General economic map (Эдийн засаг, хөгжлийн яамнаас санал авах); 7. Хуудас 16-17. Зураг 7. Livestock numbers and types; 8. Хуудас 18-19. Зураг 8-9. Road network (Зам, тээвэр хөгжлийн яамнаас санал авах); 9. Хуудас 20-21. Зураг 10-12. Tourism (шинээр байгуулагдсан жуулчны баазыг тэмдэглэх, БОАЖЯ-аас санал авах); 10. Хуудас 22-23. Зураг 13. Land cover map (чанартай газрын зургаар шинэчлэх); 11. Хуудас 30-31. Зураг 16. Metall mineral resources (Ашигт малтмал, газрын тосны газраас гаргадаг ашигт малтмалын таних тэмдэгтэй уялдуулах, АМГТГ-аас санал авах); 12. Хуудас 32-33. Зураг 17. Non metall mineral resources (Ашигт малтмал, газрын тосны газраас гаргадаг ашигт малтмалын таних тэмдэгтэй уялдуулах, АМГТГ-аас санал авах); 13. Хуудас 34-35. Зураг 18-20. Seismic activity in Mongolia (Одон орон, геофизикийн хүрээлэнгийн газар хөдлөлтийн мэдээлэлд суурилсан байх, санал авах); 14. Хуудас 50-51. Зураг 38. Vegetation; 15. Хуудас 52-53. Зураг 39. Mammals (амьтдын зургийг чанартай jpg зургаар солих); 16. Хуудас 56-57. Зураг 43. Nature protection (Тусгай хамгаалалттай газрын жагсаалтаар өөрчлөлт оруулна). 600 ширхэг хэвлэгдэх Газар зүйн атласт тавигдах шаардлага. Үүнд: - Хэмжээ: 260x365 мм; - Өнгө: 4; - Цаас: 157 грамм мат; - Хавтас: 300 грамм, бүрэлттэй; - Атласын хуудасны тоо: 32 хуудас /64 нүүр/.

7.	Ажлын хяналт, шалгалт	- ГЗБГЗЗЕГ-ын Геодези, зураг зүйн хэлтэс захиалагчийн техникийн хяналт хийнэ. Ажлын гүйцэтгэлийг шалгаж хүлээн авахад төсөвт өртгийн дүнгээс 6 хувиар тооцно. - Зураг зүйн Зөвлөх инженер захиалагчийн техникийн /редакцийн/ хяналт хийнэ.
8.	Ажлын үр дүнг хүлээлгэн өгөх	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2022 оны А/194 тоот тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлэх, шалгаж хүлээн авах журам"-ын дагуу доорх баримт бичиг, тоон мэдээллийг хүлээлгэн өгнө. Үүнд: 1. Ажил гүйцэтгэсэн дэлгэрэнгүй тайлан тоон болон хэвлэмэл байдлаар - 2%; 2. Хэвлэлийн эхийн сорьц /тоон байдлаар/ -2%; 3. Гүйцэтгэсэн ажлын тайлан атласын эхийг файлаар болон jpg байдлаар /CD,DVD/ дээр бичих - 2%; 4. 600 ширхэг хэвлэгдсэн Газар зүйн атлас.
9.	Захиалагч байгууллага	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
10.	Гүйцэтгэгч байгууллага	Зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд
11.	Санхүүжилт эх үүсгэвэр	Урсгал зардал – 40 960 192 төгрөг.
12.	Даалгаварт тусгагдаагүй ажил	Ажлын даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ.

ХЯНАСАН:

ГЕОДЕЗИ, ОРОН ЗАЙН ӨГӨГДӨЛ, ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН ДАРГА — Ж.ГАЛ

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Г.ХАЛИУНБИГЭР

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА — Д.МӨНХЦЭЦЭГ

ГЕОДЕЗИ, ОРОН ЗАЙН ӨГӨГДӨЛ, ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН — Г.ЭНХЗАЯА

БОЛОВСРУУЛСАН:

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — Ц.ОРЛОГО